



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/190

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Журам батлах тухай" А/121 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг дарга нарын захирамж, шийдвэрийн хууль зүйн үндэслэл, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж буй эсэхийг хянаж, нэгдсэн зөвлөмж, чиглэл боловсруулж, хүргүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Т.Болор (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Бичиг хэргийн эрхлэгч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)

2. Сумын Засаг даргын шийдвэрийг хянах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн зөвлөмж, чиглэлийг хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (М.Алтаншагай)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газарт (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН